

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ БОДЛОГЫГ
ТАМХИНЫ ХЯНАЛТЫН СУУРЬ КОНВЕНЦИТЭЙ
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ДҮН**

Талархал

Энэхүү судалгаа нь цаг зав гарган өөрсдийн туршлага, санал бодлоо бидэнтэй хуваалцсан мэргэжилтнүүдийн болон олон байгууллагын хамтын ажиллагааны үр дүн юм. Монгол улс дахь тамхины хяналтыг сайжруулах арга замын талаар үнэтэй санал өгсөн УИХ-ын эрхэм гишүүдэд гүн талархал илэрхийлье.

Судалгааг хийхэд техникийн болон санхүүгийн дэмжлэг харамгүй үзүүлсэн Канадын тамхины хяналтын эрдэм шинжилгээний хүрээлэн, Америкийн хавдартай тэмцэх нийгэмлэг, Их Британий хавдар судлалын төв, Олон улсын тамхины хяналтын эрдэм шинжилгээний байгууллагад талархсанаа илэрхийлье.

Судлаачид:

Б. Машбадрах

С. Төгсдэлгэр, нийгмийн эрүүл мэндийн магистр

Б. Хонгорзул, нийгмийн эрүүл мэндийн магистр

Б. Төмөрбат, нийгмийн эрүүл мэндийн магистр

Хураангуй

Тамхины эрүүл мэнд болон нийгэмд үзүүлэх хор хөнөөл нь Монгол улс улам бүр нэмэгдсээр байгаа ба тус улсын эрэгтэйчүүдийн 68,5 хувь, эмэгтэйчүүдийн 30,4 хувь нь тамхи татдаг байна.¹ Зүрх судасны зарим өвчин, хорт хавдар зэрэг тамхитай холбоотой өвчлөл нэмэгдэж, Монголын хүн амын нас баралтын тэргүүлэх хоёр шалтгаан нь болоод байна.

Гэвч цөөнгүй улс төрчид болон шийдвэр гаргагчид тамхидалтыг улс орны хөгжлийн асуудал хэмээн хүлээн зөвшөөрөхөөс татгалзсаар ирсэн. Ийм ч учраас тамхины хяналтыг бодлогын тэргүүлэх чиглэл болгох улс төрийн хүсэл эрмэлзэл Монгол улсад үгүйлэгдсэн хэвээр байна.

Энэхүү судалгаа нь тамхины хяналтын талаарх манай улсын үндэсний бодлого ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенци (ТХСК)-тэй хэр нийцэж байгааг тогтоох зорилгоор хийгдсэн ба үүний тулд дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэлээ. Үүнд: (1) тамхины хяналттай холбоотой үндэсний бодлогын баримт бичгүүдийг тоймлох, (2) сонин хэвлэл болон телевизийн нэвтрүүлгүүдийг хянах замаар тамхины сурталчилгааг хориглосон хуулийн заалтуудын хэрэгжилтийг үнэлэх, (3) санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгосон УИХ-ын гишүүдээс тамхины хяналтын талаарх бодлогын хэрэгжилт, түүнийг сайжруулах арга замын талаар ярилцлага авах.

Судалгааны дүнгээс харахад манай улсын тамхины хяналтын үндэсний бодлого ТХСК-ийн зорилт, үндсэн зарчмуудтай нийцэж байна. Гэхдээ тамхины хэрэглээг үр дүнтэй бууруулахад шаардлагатай тамхины хяналтын цогц бодлогын зарим асуудлууд Монгол улсын бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй байна. Тухайлбал, хамтрагч талуудыг дайчлах, тэдний идэвхитэй оролцоог хангахад зайлшгүй шаардлагатай тамхины хяналтыг зохицуулах үндэсний механизм бүрдүүлэх талаар огт тусгагдаагүй; олон нийтийн газар тамхи татахыг бүрэн хориглоогүй; ажлын байр болон олон нийтийн бусад газруудад тусгайлан заагдсан цэгүүдэд тамхи татахыг зөвшөөрсөн байна.

Нөгөө талаас тамхины хяналтын бодлогын хэрэгжилт туйлын хангалтгүй байна. Тамхины сурталчилгааг гурван хууль (Тамхины хяналтын тухай, Зар сурталчилгааны тухай, Олон нийтийн радио телевизийн тухай хууль)-иар хориглосон боловч тамхи үйлдвэрлэгчид өөрсдийн бүтээгдэхүүнийг мэдээллийн бүхий л сувгаар чөлөөтэй сурталчилж, түүнийгээ эрүүл мэндэд хоргүй мэт ташаа мэдээллийг хүн амд хүргэсээр байна.

Тамхины хяналттай холбоотой дээрх дутагдлууд улс төрийн чин эрмэлзэл дутмаг байгаатай холбоотой юм. Тамхи үйлдвэрлэгчид улс төрийн хүчнүүдтэй холбоо сүлбээтэй² ба хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд хүчтэй эдийн засгийн нөлөө үзүүлж чадаж байна. Санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгосон УИХ-ын 12 гишүүнээс нэг нь ч ТХСК-ийн талаар мэдэхгүй байсан нь сэтгэл түгшээсэн асуудал юм. Мөн ярилцлага өгсөн нэгээс бусад бүх гишүүд тамхины үйлдвэрлэлийг дэмжсэн, түүнд төрийн оролцоог аль болох бага байлгаж, зах зээлийн жамаар нь хөгжүүлэхийг санал болгож байсан нь туйлын харамсалтай.

Судалгааны дүнд үндэслэн тамхины хяналтын цогц бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагааг манлайлах Үндэсний тамхины хяналтын салбар хоорондын хороо байгуулах, тамхины хяналтын асуудалд орон нутгийн засаг захиргааны оролцоог нэмэгдүүлэх, тамхитай холбоотой үнэн бодит нотолгоогор хангах эрдэм шинжилгээний ажлуудыг дэмжих, тамхи үйлдвэрлэгчдийн сурталчилгаанд зарцуулж буй хөрөнгийн хэмжээг тогтоох зэргийг зөвлөмж болгож байна.

¹ Н. Нямдаваа, Ж. Чинбүрэн Элэгний анхдагч өмөнтэй холбоотой хүн амын мэдлэг, хандлага, дадлын судалгаа. УБ. 2003 (www.moh.mn/moh%20db/HealthReports.nsf)

² УИХ-ын гишүүн Ц. Шаравдоржтой хийсэн ярилцлагаас

Монгол улсын үндэсний бодлогыг Тамхины хяналтын суурь конвенцтэй харьцуулсан судалгааны дүн

1. Үндэслэл

Тамхины эрүүл мэнд болон нийгэмд үзүүлэх хор хөнөөл нь Монгол улсад улам бүр нэмэгдсээр байгаа ба тус улсын эрэгтэйчүүдийн 68,5 хувь, эмэгтэйчүүдийн 30,4 хувь нь тамхи татдаг байна.³ Энэ нь хөгжиж байгаа болон хөгжингүй улс орнууд дахь тамхи таталтын дундаж түвшингээс өндөр үзүүлэлт юм.⁴

Залуучууд, эмэгтэйчүүдийн дунд тамхи таталт нэмэгдэж байгаа нь онцгой анхаарах ёстой асуудал юм. 1999 онд үндэсний хэмжээнд хийсэн судалгаагаар их, дээд сургуулийн оюутнуудын 86,3% нь тамхи татдаг байжээ. Тамхи анх татаж эхлэх нас нь охидуудад 16,7 харин хөвгүүдэд 17,2 байв. 10-13 настай хүүхдүүдийн хувьд хөвгүүд тамхи татах нь охидуудаас 4 дахин их байсан бол 14-20 насны бүлэгт энэхүү ялгаа нь бараг арилдаг байна.⁵

Зүрх судасны зарим өвчин, хорт хавдар зэрэг тамхитай холбоотой өвчлөл нэмэгдэж, Монголын хүн амын нас баралтын тэргүүлэх хоёр шалтгаан нь болоод байна.⁶ Тухайлбал, уушигны өмөн Монгол эрэгтэйчүүдийн хавдрын нас баралтын хоёр дахь, эмэгтэйчүүдийн тав дахь тэргүүлэх шалтгаан болж байна.⁷

Гэвч цөөнгүй улс төрчид болон шийдвэр гаргагчид тамхидалтыг улс орны хөгжлийн асуудал хэмээн хүлээн зөвшөөрөхөөс татгалзсаар ирсэн. Ийм ч учраас тамхины хяналтыг бодлогын тэргүүлэх чиглэл болгох улс төрийн хүсэл эрмэлзэл Монгол улсад үгүйлэгдсэн хэвээр байна. Тамхины хяналттай холбоотой бодлогын баримт бичгүүдийн батлагдсан огноог харахад л тамхины хяналтын асуудалд улс төрийн манлайлал хэр чухал болохыг мэдэж болно. Манай улсын тамхины хяналтын талаарх анхны бодлогын баримт бичиг болох Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хууль нь Эрүүл мэндийн Сайдын манлайлал дор, ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр 1993 онд батлагджээ. 1996 он буюу шинэ Засгийн газар байгуулагдан, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын шинэ сайд томилогдох хүртэлх хугацаанд тамхины хяналтын талаар нэмж бодлогын 4 баримт бичиг батлагджээ. Харин 1996-2000 онуудад тамхины хяналтын асуудлаар дорвитой ахиц гараагүй байна. Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хуулийг батлуулах ажлыг манлайлсан Эрүүл мэндийн сайд 2000 онд дахин сонгогдож, Монгол улсын тамхины эсрэг тэмцлийг дахин тэргүүлж, 2000-2004 онуудад тамхины хяналттай холбоотой 12 бодлогын баримт бичиг, үүн дотор ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц (ТХСК)-ийг батлуулжээ. Мөн түүний санаачилгаар боловсруулсан Тамхины хяналтын тухай хууль, Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр зэрэг нь 2005 онд батлагдсан байна.

³ Н. Нямдаваа, Ж. Чинбүрэн Элэгний анхдагч өмөнтэй холбоотой хүн амын мэдлэг, хандлага, дадлын судалгаа. УБ. 2003 (www.moh.mn/moh%20db/HealthReports.nsf)

⁴ ДЭМБ. Тамхины хэрэглээ, түүнтэй холбоотой нас баралтын хандлага дэлхий дахинд (<http://www.druglibrary.org/SCHAFFER/tobacco/who-tobacco.htm>)

⁵ Өсвөр үеийнхний эрүүл мэндийн мэдлэг, дадлага, хандлагын судалгааны тайлан, ЭМЯ ба ДЭМБ, УБ, 1999

⁶ Эрүүл мэндийн статистик мэдээ, ЭМЯ, УБ, 2005

⁷ Хорт хавдрын статистик мэдээ, Хавдар судлалын төв, УБ, 2005

Гэвч ТХСК болон тамхины хяналтын үндэсний бусад бодлогын хэрэгжилт туйлын хангалтгүй байна. Тухайлбал, ТХСК-ийн 5-р зүйл (“тамхины хяналтын салбар хоорондын үндэсний цогц стратегийг конвенцитэй нийцүүлэн боловсруулах”), 16-р зүйл (“хүүхдэд тамхины бүтээгдэхүүнийг худалдаалахыг хориглох”) болон 13-р зүйл (“тамхины бүх төрлийн сурталчилгааг хориглох”) хамгийн ихээр зөрчигдөж байна.

Иймээс тамхины хяналтын талаарх манай улсын үндэсний бодлого ТХСК-тэй хэр нийцэж байгааг тогтоох, ТХСК-ийн хэрэгжилтийг сайжруулах стратегийн зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү судалгааг хийсэн юм.

2. Зорилго, зорилтууд

Судалгааны зорилго нь ДЭМБ-ын ТХСК-ийн Монгол улс дахь хэрэгжилтийг үнэлэх, үнэлгээний дүн, зөвлөмжүүдийг олон нийт, хэрэгжүүлэгч байгууллагууд болон шийдвэр гаргагч нарын сонорт хүргэхэд оршино.

Зорилтууд:

1. Тамхины хяналттай холбоотой үндэсний хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрүүд ТХСК-ийн зорилт, үндсэн зарчмуудтай хэр нийцэж байгааг үнэлэх
2. Тамхины сурталчилгааг хориглох талаар ТХСК-ийн заалтуудын хэрэгжилтийг үнэлэх
3. ТХСК-ийн хэрэгжилтийг сайжруулах талаар стратегийн зөвлөмж боловсруулах
4. Судалгааны дүнг олон нийт болон шийдвэр гаргагчдад түгээх

3. Арга зүй

Тамхины хяналтын асуудалтай холбоотой үндэсний бодлогын баримт бичгүүдийн тойм хийж, тэдгээр нь ТХСК-ийн зорилт, үндсэн зарчим, заалтуудтай хэр нийцэж байгааг тогтоосон (судалгаанд хамрагдсан бодлогын баримт бичгүүдийн жагсаалтыг Хавсралт 1-ээс үзнэ үү). Нийт 29 бодлогын баримт бичгийг судалгаанд хамруулснаас 25 нь Монгол улс ТХСК-д нэгдэхээс өмнө буюу 2004 оноос өмнө батлагдсан байна.

Сонин хэвлэл болон телевизийн нэвтрүүлгүүдийг хянах замаар тамхины сурталчилгааг хориглосон хуулийн заалтуудын хэрэгжилтийг үнэлсэн. Сэрүүлэг, Өнөөдөр, Өдрийн мэдээ сонины 2004 оны дугаарууд, MN болон UBS телевизийн 2005 оны 12-р сарын амралтын өдрүүдийн хөтөлбөрүүд, Улаанбаатар хотын Энх тайвны өргөн чөлөө, Залуучуудын өргөн чөлөө болон Нарны замын сурталчилгааны самбаруудад ажиглалт хийж, тамхины сурталчилгааны цар хүрээг тогтоосон.

Эцэст нь, санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгосон УИХ-ын 12 гишүүнээс тамхины хяналтын талаарх бодлогын хэрэгжилт, түүнийг сайжруулах арга замын талаар ярилцлага авсан.

Бодлогын баримт бичгийн тойм хийх хяналтын хуудас (Хавсралт 2), хэвлэл мэдээллийн тойм хийх хяналтын хуудас (Хавсралт 3), хууль тогтоогчидтой хийх ярилцлагын маягт (Хавсралт 4)-ыг ашиглан судалгааны мэдээг цуглуулсан.

4. Судалгааны дүн

4.1 Бодлогын баримт бичгийн тойм

Тамхины хяналтын бодлогын баримт бичгүүдийг тоймлоход тамхины хэрэглээг үр дүнтэй бууруулахад шаардлагатай тамхины хяналтын цогц бодлогын зарим асуудлууд Монгол улсын бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй байна. Тухайлбал, тамхины эрэлтийг бууруулахад чиглэсэн ТХСК-ийн хэд хэдэн заалт манай үндэсний бодлогуудад тусгалаа олоогүй байна. Үүнд:

- тамхи үйлдвэрлэгчид болон импортлогчдын зүгээс тамхины хорт бодисын агууламж, тэдгээрийн ялгарах хэмжээг Засгийн газарт үнэн зөвөөр мэдээлэх;
- тамхийг хаана (аль бүс, улс орон г.м.) худалдаалахыг зөвшөөрсөн талаар мэдээлэл тамхины бүх сав баглаан дээр байрлуулах;
- тамхийг хүүхдэд худалдаалахгүй талаар тодорхой, харагдахуйц самбарыг тамхи худалдаалж буй бүх цэгт байрлуулах;
- тамхийг шууд хүртээмжтэй хэлбэрээр (ж.нь, өөртөө үйлчлэх тасгийн лангуугаар) худалдаалахыг хориглох;
- чихэр, амттан, тоглоом зэрэг хүүхдүүдийн сонирхлыг татахуйц зүйлсийг тамхины хэлбэртэй үйлдвэрлэх, ийм зүйлсийг худалдаалахыг хориглох.

Гэхдээ манай улсын тамхины хяналтын үндэсний бодлого ерөнхийдөө ТХСК-ийн зорилт, үндсэн зарчмуудтай нийцэж байна.

4.1.1 Тамхины хяналтын зохицуулга ба санхүүжилт

Тамхины хяналтын талаарх манай улсын үндэсний бодлогод хамтрагч талуудыг дайчлах, тэдний идэвхитэй оролцоог хангахад зайлшгүй шаардлагатай тамхины хяналтыг зохицуулах үндэсний механизм бүрдүүлэх асуудал тусгагдаагүй. Бодлогын нэг ч баримт бичигт тамхины хяналтын үндэсний зохицуулах механизм байгуулна гэсэн заалт үгүй байна. Засгийн газрын 2002 оны 149-р тогтоолоор байгуулагдсан Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хороо нь нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын хамтын ажиллагааг зохицуулах үүрэгтэй тул тус хороо нь тамхины хяналтыг зохицуулах механизмын үүргийг гүйцэтгэнэ гэж албаны хүмүүс хэлж байгаа боловч Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хороо нь байгуулагдсан цагаасаа хойш тамхины хяналтын асуудлыг нэг ч удаа хэлэлцээгүй байна. Цаашилбал, 2005 онд буюу Монгол улс ТХСК-д нэгдсэнээс хойш батлагдсан Тамхины хяналтын тухай хууль нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, стандартчиллын үндэсний зөвлөл зэрэг байгууллагуудын гүйцэтгэх үүргийг тодорхойлсноор тамхины хяналтын асуудал дахь салбар хоорондын оролцоог хязгаарласан гэж үзэж болохоор байна.

Тамхины хяналтыг үр дүнтэй байлгах нэг гол урьдчилсан нөхцөл нь өөрийгөө санхүүжүүлэх чадвар бөгөөд энэ асуудлыг үндэсний бодлогын баримт бичгүүдэд

тусгасан нь томоохон амжилт юм. УИХ-ын 2001 оны 81-р тогтоолоор баталсан Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогод хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг архи, тамхины онцгой албан татварын тодорхой хэсгийг хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд зарцуулна гэж заажээ. Түүнээс гадна Тамхины хяналтын тухай хуульд онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хөрөнгөөс бүрдэх эрүүл мэндийг дэмжих сан байгуулж, сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай санд төвлөрүүлнэ гэж заасан нь тамхитай тэмцэх үйл ажиллагааны санхүүжүүлтийн тогтвортой эх үүсвэрийг бий болгох ач холбогдолтой болжээ.

4.1.2 Тамхины эрэлтийг бууруулах

Үнэ, татварын арга хэмжээ

Тамхины хяналтын тухай хуульд тамхины татварыг тасралтгүй нэмэгдүүлэх замаар тамхины хяналт, хүн амын эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг тогтвортой санхүүжүүлж, насанд хүрээгүй иргэнийг тамхинд орохоос сэргийлэх, тамхины хэрэглээг бууруулах зарчмыг баримтална гэж заасан нь ТХСК-ийн бодлогыг дэмжсэн байна. Онцгой албан татварын тухай хуулинд 1995, 1997, 1999, 2000, 2001, 2004 онуудад нэмэлт өөрчлөлт оруулах замаар тамхинд ногдуулах онцгой албан татварыг зургаан удаа нэмсэн байна. Одоогийн байдлаар бүх төрлийн янжуур болон бусад тамхинд онцгой албан татвар ногдуулах ба эх орны үйлдвэрийн бараа бол 100 ширхэг тутамд 0,60, импортынх бол 100 ширхэг тутамд 0,30; дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины 1 кг тутамд эх орны үйлдвэрийнх бол 0,30, импортын бол кг тутамд 0,30 ам долларын татвар ногдуулахаар заажээ.

Гадаад, дотоодын зорчигдод татвараас чөлөөлсөн тамхи зарах буюу импортлохыг хориглосон/хязгаарласан заалтын тухайд ГЕГ-ын даргын 2002 оны 115 тоот тушаалаар 16-аас дээш насны зорчигч янжуур 200 ш, навчин тамхи 50 ширхэг, задгай тамхи 250 граммаас илүүгүй хэмжээгээр гаалийн болон бусад албан татваргүйгээр гаалийн хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрчээ.

Тамхины хорт нөлөөнөөс хамгаалах арга хэмжээ

Олон нийтийн газар тамхи татахыг бүрэн хориглоогүй байна. 2005 оны тамхины хяналтын тухай хуулинд нийтийн тээврийн хэрэгсэлд утаат тамхи татахыг хориглосон боловч ажлын байр болон олон нийтийн бусад газруудад тусгайлан заагдсан цэгүүдэд тамхи татахыг зөвшөөрчээ. Мөн нийтийн хоолны газруудын хувьд хоёр ба түүнээс дээш үйлчилгээний танхимтай газрууд л тамхи татдаггүй хүмүүст зориулсан тусгай танхим ажиллуулна гэжээ.

Тамхины эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний талаар мэдээллийг тамхины сав баглаан дээр байрлуулахыг шаардсан хууль тогтоомжийн заалтууд хоорондоо зөрчилдөж байна. Тухайлбал, Янжуур тамхины стандартад тамхины хайрцаг, боодол дээр эрүүл мэндэд нөлөөлөх хор хөнөөлийн талаар монгол, англи хэлний аль нэгээр бичнэ гэжээ. Ингэхдээ янжуурын хайрцгийн ар, өвөр 2 талын нүүрний 20%-иас доошгүй талбайг эзэлсэн цагаан дэвсгэр дээр тод үсгээр бичиж, хараар хүрээлсэн байх ёстой бөгөөд энэ мэдээллийг тамхины хайрцгийг онгойлгох үед гэмтэж болох хэсэгт бичиж болохгүй хэмээн заажээ. Харин Тамхины хяналтын тухай хуулинд тамхи нь эрүүл мэндийн хор нөлөөний тухай монгол хэлээр бичсэн анхааруулгатай

байна. Анхааруулга нь тамхины хайрцагны эргэн тойрны гадаргууны гуравны нэгээс багагүй тайлбайг эзэлсэн байх, тамхин бүтээгдэхүүнээс хүний эрүүл мэндэд учруулах хор нөлөөний талаар том хэмжээтэй, харагдахуйц, гаргацтай бичих, зураг буюу дүрсээр харуулах шаардлагыг хангасан байх ёстой ажээ.

Тамхины хяналтын тухай хуулинд (2005) тамхи үйлдвэрлэгчид болон импортлогчдын зүгээс тамхины хорт бодисын агууламж, ялгарах хэмжээг үнэн зөвөөр мэдээлэхийг шаардсан заалт байхгүй. Харин Эрүүл мэндийн сайдын “Тамхины хор хөнөөлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” 1994 оны а/15 тоот тушаал, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 194 тоот тушаалд монгол улсад импортлох, үйлдвэрлэх тамхины найрлага дахь никотин, бохины зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоосон ба тамхинд агуулагдаж буй бохь, никотины хэмжээг тамхины хайрцаг, сав баглаан дээр заасан байна гэжээ.

Тамхины сурталчилгааны эсрэг арга хэмжээ

Тамхины хяналтын хуульд тамхи болон тамхины үйлдвэрийн нэр, тэмдэг, түүнтэй холбоотой зураг ашиглах замаар тамхийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, кино, интернет, ханын самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз болон бусад биет байдлаар сурталчлахыг хориглосон. Зар сурталчилгааны тухай хуульд хуулиар сурталчлахыг хориглосон бараа, ажил, үйлчилгээг сурталчлах, Олон нийтийн радио телевизийн тухай хуульд олон нийтийн радио телевизээр арилжааны болон далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно гэсэн заалтуудад тамхины зар сурталчилгааг хамааруулж болохоор байна.

Тамхины хяналтын тухай хуульд тамхи үйлдвэрлэгчээс соёл урлаг, биеийн тамир, спортын болон бусад олон нийтийн арга хэмжээнд ивээн тэтгэгчээр оролцох, төрөл бүрийн хандив, тусламж, тэтгэлэг үзүүлэхийг хориглосон. Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд хуулиар сурталчлахыг хориглосон бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, ажил үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд аливаа нэвтрүүлгийг ивээн тэтгэхийг хориглоно гэжээ.

4.1.3 Тамхины нийлүүлэтийг бууруулах

Тамхины хууль бус худалдаа

Тамхины хяналтын тухай хуулиар хайрцаг, сав, баглаа боодол дээр онцгой албан татварын тэмдэг, үйлдвэрлэсэн улс, он, сар, үйлдвэр, импортлогчийн нэр, Монгол улсад худалдахыг зөвшөөрсөн тухай тэмдэглэлгүй тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдахыг хориглосон. Мөн “Монгол улсад үйлдвэрлэв” гэсэн шошготойгоор бусад улсад үйлдвэрлэсэн тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдахыг хориглосон байна.

Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2001 оны 84 тоот тушаалаар батлагдсан “Онцгой албан татварын тэмдэггүй болон хуурамч тэмдэг бүхий архи, тамхийг хураан авч улсын орлого болгох журам”-д чанар, стандарт, эрүүл ахуйн хяналтын шинжилгээнд тэнцээгүй, хүний хэрэгцээнд таарахгүй хураагдсан тамхийг устгана гэсэн боловч тамхины хууль бус үйлдвэрлэл худалдаа эрхлэж байсан багаж тоног төхөөрөмжийг устгах талаар заагаагүй байна.

Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйлдвэрлэгдэж, хадгалагдаж, худалдаалагдаж буй тамхины хөдөлгөөнийг хянах, баримтжуулах, хянах үндсэн хэрэгслүүд нь тамхины үйлдвэрлэл, худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл, тамхинд ногдох онцгой албан татвар, нэмэгдсэн өртгийн татвар байхаар холбогдох хуулиудад тусгасан байна. 2001 оны “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуульд тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхэлнэ гэж заажээ. 2005 оны Тамхины хяналтын тухай хуулинд тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүнс, хөдөө, аж ахуйн, тамхи импорлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Засгийн газар, тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сум, дүүргийн засаг дарга олгоно гэсэн нь тамхины үйлдвэрлэл, худалдааг лицензжүүлэх ажлын эрх зүйн орчныг нь бүрдүүлжээ. Тамхины бүтээгдэхүүний хөдөлгөөнийг бүртгэж, мэдээлэх үйл ажиллагаа дараах дүрэм журмуудаар зохицуулагддаг байна. Үүнд: Импортын архи, дарс, тамхины онцгой албан татвар болон онцгой албан татварын тэмдгийн талаарх мэдээлэл солилцох журам (Үндэсний татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын даргын 2002 оны хамтарсан 159/446 тоот тушаал), Тайлангийн маягт, загварыг шинэчлэн батлах тухай Үндэсний татварын ерөнхий газрын даргын 115 тоот тушаал (2005), Хилийн мэргэжлийн хяналтын албаны дүрэм батлах тухай Улсын мэргэжлийн хяналтын газрын даргын 134 тоот тушаал (2003).

Тамхийг хүүхдэд худалдах, тэднээр худалдуулахыг хорих тухай

Тамхины хяналтын тухай хуульд 18 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, тэднээр тамхи худалдуулахыг хориглосон бөгөөд энэ заалтыг зөрчсөн иргэн, албан хаагч, хуулийн этгээдийг торгох, тамхи болон хууль бусаар олсон орлогыг хураах зэрэг шийтгэл оногдуулахаар заажээ.

Тамхины хяналтын тухай хуулинд тамхийг ширхэглэн худалдах, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины үйлдвэрлэсэн боодлыг задалж буюу ороож худалдахыг хориглосон байна. Янжуур тамхины стандартад янжуур тамхийг 1 хайрцагт 20 ш-ээс багагүй тоогоор савласан байхаар заажээ. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 228 тоот тушаалаар батлагдсан “Тамхи импортлоход зөвшөөрөл олгох, түүнд эрүүл ахуйн хяналт тавих” журамд тамхи хандивлах, тамхины төрлийн бүтээгдэхүүнийг сурталчлан ивээн тэтгэхийг хориглосон байна.

4.1.4 Тамхины судалгаа, мэдээлэл солилцох үйл ажиллагаа

Тамхины талаарх судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих, мэдээлэл солилцох үйл ажиллагааны зохицуулалтын талаар Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрт нэлээд заалтуудыг, тухайлбал халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтын байдлыг тогтмол судлан тандах тогтолцоог бүрдүүлэх талаар заалт оруулж өгсөн байна.


4.2 Хэвлэл мэдээллийн тойм

Хэвлэл мэдээллийн тойм хийх явцад тамхины сурталчилгааг гурван хууль (Тамхины хяналтын тухай, Зар сурталчилгааны тухай, Олон нийтийн радио

телевизийн тухай хууль)-иар хориглосон боловч тамхи үйлдвэрлэгчид өөрсдийн бүтээгдэхүүнийг мэдээллийн бүхий л сувгаар чөлөөтэй сурталчилж байгаа болох нь тогтоогдлоо.

Сонины 784 дугаарыг тоймлон үзэхэд 52 дугаарт (6.7%) нь тамхины сурталчилгаа нийтлэгдсэн байв. Харин тамхины эсрэг сурталчилгаа зөвхөн 4 дугаарт (0.5%) гарсан нь Бүх нийтээрээ тамхи татахгүй өдөрт зориулж ЭМЯ-аас нийтлүүлсэн хэвлэлийн мэдээлэл, ЭМЯ-аас тамхины сурталчилгааны эсрэг гаргасан нэг мэдэгдэл, 2 нийтлэл байжээ.

Тамхины сурталчилгаа нь “тамхи борлуулагч ажилд авна” гэсэн ажлын зар, тамхи үйлдвэрлэгчийн ивээн тэтгэж байгаа урлагийн томоохон арга хэмжээний зарлал, тамхины урамшуулалт худалдаа, тамхины урамшууллын тохирол г.м. маш олон хэлбэрээр хийгдэж байна.




*Төгс бүхний илэрхийлэл болсон LANDUS
брэнд “Гоёл” наадмын өнгө жавхаанд хөг
нэмэх нь гарцаагүй*

*“Дэлхийд нэр хүндтэй Солонгосын KT&G
корпорацийн үндсэн зорилгуудын нэгд
нийгмийн сайн сайхан үйлсийн төлөө
хөрөнгө оруулах явдал байдаг. Landus-ын
үндсэн санаа нь ТӨГС ЕРТӨНЦ. Бид Landus
брэндийг үйлдвэрлэхдээ өндөр зэрэглэлийн,
нийгмийн тухайн үеийн чиг хандлагыг
тодорхойлогч хэрэглэгчийн сонолт байх
ёстой хэмээн үзсэн”*

*О. Амартүвшин
Адел компанийн захирал
Landus-ийн албан ёсны дистрибьютор*

Тамхи үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ сурталчилахдаа “барууны стиль”, “тансаг хэрэглээ”, “сайхан амьдрал” гэсэн санаануудыг түлхүү ашиглаж залуучууд, бага орлоготой иргэдийг татах аргыг ашиглаж байна.

*“Davidof –ын сайжруулсан шинэ дизайн..Бид таньд тамхины шинэ таатай
мэдрэмжинд нэг алхамурагшаа чиглэх боломжийг өгч байна... Та манай шинэ
хайрцагнаас тамхины төгс төгөлдөр чанарямар байх ёстойг төсөөлөн мэдрэх
боломжтой...Брэндүүд өөрийн гэсэн онцлог давуу талтай байдаг. Харин Davidoff нь
“амьдралын хамгийн дээд баяр баяслыг” агуулсан.*



АНГЛИ ЧАНАР

Хоосон хайрцагны урамшуулал



*Та 30 хайрцагаар LD гоймон 2 уут
50 хайрцагаар LD гурил 2 уут
100 хайрцагаар LD гурил 5 кг
150 хайрцагаар LD цагаан будаа 5 кг
200 хайрцагаар LD элсэн чихэр 3 кг + LD
цагаан будаа 3 кг
300 хайрцагаар LD гурил 10 кг + LD
цагаан будаа 3 кг
500 хайрцагаар LD гурил 10 кг + LD
цагаан будаа 3 кг + LD элсэн чихэр 3 кг
авна*

Мөн тамхны сурталчилгаа нь тамхи үйлдвэрлэх технологийг танилцуулах нэрийдлээр “сүүлийн үеийн технологийг ашиглан эрүүл мэндэд хор хөнөөл багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна” гэсэн сурталчилгаа явуулж байна.

“Нүүрсэн шүүлтүүр – Таны эрүүл мэндийн баталгаа. Энэхүү бүтээгдэхүүний давхар нүүрсэн шүүлтүүр нь тамхины бүх хорт бодисуудыг найдвартай шүүж, Таны эрүүл мэндийг хамгаална.”

“Сонголт тань зөв гэж үү? Монголын бүх одод хатуу тамхинаас татгалзаж, эрүүл мэндээ эгнэгт анхаарч явахыг уриалж байна. KT&G группийнхэн өөрсдийн технологийг тасралтгүй сайжруулж, тамхины амтыг хэвээр хадгалж, бохь никотинныг нь буурууллаа. Энэ бол KT&G-ийн LANDUS, MOUNT зэг дэлхийн шилдэг брэндүүд тамхины хаан гэсэн титэм зүүх бас нэг шалтгаан байсан биз ээ. Энэ их айл жил бүр 50 сая долларыг хүний биед хор хөнөөлгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрэл хайгуулын ажилд “цацсаар” байна. Хэрэглэгч Та шилэн лангууны цаана ярайтал өрсөн бүтээгдэхүүн рүү гараа явуулахаасаа өмнө алийг нь сонговол хэрэгцээнд тань бүрэн нийцэхийг заавал бодолцож байгаарай!”

Үндэсний MN болон UBS телевизүүдийн амралтын өдрүүдийн нэвтрүүлгүүдийг тоймлоход нийт 15 киноны 5 нь тамхи татаж байгаа хүмүүсийн дүрсийг харуулсан байв. Түүнчлэн UBS телевизийн цаг агаарын мэдээ нь Landus тамхины ивээн тэтгэсэн, тайзан дээрээ Landus-ийн сурталчилгааны самбарыг байрлуулсан “Гоёл” шоуны бичлэгийг фон болгон ашиглажээ. Мөн Landus тамхи асааж буй дүрс бүхий дууны хоёр клип цацагдсан байна.



Улаанбаатар хотын томоохон гурван гудамжинд (Энх тайвны өргөн чөлөө, Залуучуудын өргөн чөлөө, Нарны зам) тамхины нийт 12 реклам сурталчилгаа байсан ба эдгээрийн 8 нь Davidoff-ийн реклам байв. Түүнээс гадна хотын бараг бүх ТҮЦ, автобусны буудлуудыг тамхины сурталчилгаагаар “чимсэн” байна.

4.3 Хууль тогтоогчидтой хийсэн ярилцлага

Санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгосон УИХ-ын 12 гишүүнтэй ярилцлага хийсэн (ярилцлага өгсөн УИХ-ын гишүүдийн нэрсийн жагсаалтыг Хавсралт 5-аас үзнэ үү). Тэдгээрийн 11 нь эрэгтэй, 4 нь тамхи татдаг байв.

Ярилцлага өгсөн 2 гишүүн манай улсад үйлчилдэг тамхины хяналттай холбоотой ямар нэгэн хууль, журам нэрлэж мэдэхгүй байв. Бусад нь зөвхөн Тамхины хяналтын хуулийг нэрлэж байсан ба ТХСК-ийн талаар нэг ч гишүүн дурьдсангүй. Ярилцлага өгсөн УИХ-ын гишүүд Тамхины хяналтын тухай Монгол улсын хууль журмын хэрэгжилтийг ерөнхийд нь “муу” гэж үнэлсэн, ялангуяа олон нийтийн газар тамхи татах, хүүхдэд тамхи худалдах, тамхийг ширхэглэн худалдаалахыг хориглосон заалтуудын хэрэгжилтийг маш хангалтгүй гэж үзсэн байна. Хууль журмын хэрэгжилт ийнхүү хангалтгүй байгаагийн шалтгааныг хуулийн хяналт муу, улс төрийн манлайлал дутмаг, тамхины бизнес улс төртэй холбогдсоноор тайлбарлажээ.

“Хуулийг гаргаад мартдаг. Хууль гаргах нэг удаагийн л арга хэмжээ болоод өнгөрч байна. Гэтэл тамхины хор нөлөө нь нэмэгдээд л байдаг.”

Т. Бадамжунай, УИХ-ын гишүүн

“Төрийн өндөр алба хашиж байгаа хүмүүсийн дотор тамхины бизнес эрхэлдэг хүмүүс байсан, одоо ч байсаар байна. Төр өөрөө маш идэвхигүй, ажиллахгүй байна. Тамхийг янз бүрийн байдлаар сүүлийн үед маш их сурталчилж байна. Төсвийн тодтогдол хийж байхад тамхитай тэмцэх сангийн асуудал огт яригдахгүй байна. Хяналт тавидаг бүх байгууллага ажлаа хийхгүй байна гэсэн үг. Ер нь [Тамхины хяналтын тухай] хуулийг хэрэгжүүлж байгаа тухай огт сонсогдохгүй байна”

Ц.Шаравдорж, УИХ-ын гишүүн

Ярилцлага өгсөн ихэнх гишүүд тамхины бүх төрлийн сурталчилгаа, тухайлбал гудамжны самбар, спортын болон урлагийн арга хэмжээнүүдийг тамхи үйлдвэрлэгчид ивээн тэтгэх, брэнд нэрийн сурталчилгаа, Засгийн газрын ордонд тамхийг бэлгэнд тараах зэрэг бүх төрлийн хэлбэрээр маш их явагдаж байна, иймээс тамхины сурталчилгааг хориглосон хуулийн заалтуудыг хатуу хэрэгжүүлэх нь зүйтэй гэдэг байр суурьтай байсан. Харин дөрвөн гишүүн тамхины сурталчилгаа манай улсад бараг байдаггүй, нэг нь бүр “Сурталчлахыг учиргүй эсэргүүцээд байдаггүй. Сурталчилснаар тамхинд орох нь юу л бол. Хүн өөрөө л сурталчилгаанд автахгүй байх нь чухал” гэжээ.

Зөвхөн нэг гишүүн тамхины үйлдвэрлэл Монголд хэрэггүй гэсэн байна. Бусад нь бүгд хэрэглээ байгаа, эдийн засгийн хувьд ашигтай тул тамхины үйлдвэрлэл манай улсад байх нь зүйтэй, “үүнд төрийн оролцоо хүчтэй байх шаардлагагүй, зах зээлийн жамаараа л хөгжих ёстой. Харин чанарын хяналтыг хатуу тавих, эрүүл мэндэд хор хөнөөл багатай тамхи үйлдвэрлэх хэрэгтэй”, нэг гишүүн “Тэр ч байтугай тариалан ч байж болох юм” гэжээ.

Тамхины хэрэглээг хэрхэн бууруулж, тамхины хяналтыг чангатгах арга замын талаар асуухад дөрвөн гишүүн “хүний зан үйлийг хуулиар зохицуулах боломжгүй”, “тамхины сурталчилгаа, тамхины үйлдвэрлэл, тамхины ширхэглэн худалдаа зэрэг нь зах зээлийн хүчин зүйлсээр зохицуулагддаг учир энэ талаар төрөөс хийж чадах зүйл хомс” гэсэн байр суурь илэрхийлэв. Бусад нь Тамхины хяналтын тухай хуульд тамхины сурталчилгааг хориглох, олон нийтийн газар тамхи татахыг хориглох, насанд хүрээгүй хүмүүст тамхи зарахыг хориглох, тамхийг ширхэглэн зарахыг хориглох заалтуудыг нэмж оруулъя гэж байв (эдгээр заалтууд бүгд тус хуулинд туссан байгаа). Мөн хүн ам, ялангуяа хүүхэд, залуучуудын дунд сургалт, сурталчилгаа явуулж, тамхины хор хөнөөлийг ойлгуулах, орон нутгийн засаг захиргааны үүрэг оролцоог нэмэгдүүлэх, улс төрийн манлайллыг бий болгох асуудлуудад ач холбогдол өгч байлаа.

“Тамхины эсрэг үйл ажиллагаа сургуулиудад маш бага хийгдэж байна. Тамхины эсрэг сурталчилгааг ЕБС-д оруулж өгөх хэрэгтэй”

Т. Бадамжунай, УИХ-ын гишүүн

“Орон нутгийн захиргаа сайн ажиллах хэрэгтэй. Хүн амынхаа эрүүл мэндийг тэд хариуцах ёстой. Тэд хурлаараа энэ асуудлыг авч хэлэлцдэг байх ёстой. Засаг дарга нарыг үүргээр нь шахах хэрэгтэй”

Г. Адъяа, УИХ-ын гишүүн

“ТББ-уудаас санаачлага гаргах нь чухал байна”

С. Ламбаа, УИХ-ын гишүүн

“Манай хууль бол сайн хууль. Өндөр хөгжилтэй оронд байдаг заалтууд манай хуулинд бүгд бий. Хуулиа л хэрэгжүүлэх ёстой. Хууль хэрэгжүүлдэг байгууллагууд л сайн ажиллах ёстой”

Р. Эрдэнэбүрэн, УИХ-ын гишүүн

“Тамхины хяналтын асуудалд өрөвдөх, хүндэтгэх шалтгаан, буулт хийх гэдэг асуудал байж болохгүй гэж үздэг. Төр, бизнес холилдсон одоогийн нөхцөлд төр хүчгүйдэж байна. Улс төрийн хүчтэй коалици бий болгох хэрэгтэй”

Ц.Шаравдорж, УИХ-ын гишүүн

5. Дүгнэлт

Судалгааны дүнгээс харахад манай улсын тамхины хяналтын үндэсний бодлого ТХСК-ийн зорилт, үндсэн зарчмуудтай нийцэж байна. Гэхдээ хуулийн зарим заалтууд тодорхой бус, хоорондоо зөрчилдсөн, тамхины хяналтын бодлогын хэрэгжилт туйлын хангалтгүй байна.

Монгол улс эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн дундах тамхи таталтын түвшингээр дэлхийд нэлээн дээгүүрт орж байна. Гэсэн хэдий ч тамхины хяналтыг зохицуулах үндэсний механизм байхгүй, тамхинд ногдуулах онцгой албан татвар багатай орон хэвээр байна.

Онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хөрөнгөөс бүрдэх эрүүл мэндийг дэмжих сан байгуулж, сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай санд төвлөрүүлнэ гэсэн хуулийн заалт байдаг боловч уг сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хомс байна. Олон нийтийн газар тамхи татахыг бүрэн хориглоогүй, ажлын байр болон олон нийтийн бусад газруудад тусгайлан заагдсан цэгүүдэд тамхи татахыг зөвшөөрсөн байна.

Тамхины сурталчилгааг гурван хууль (Тамхины хяналтын тухай, Зар сурталчилгааны тухай, Олон нийтийн радио телевизийн тухай хууль)-иар хориглосон боловч тамхи үйлдвэрлэгчид өөрсдийн бүтээгдэхүүнийг мэдээллийн бүхий л сувгаар чөлөөтэй сурталчилж, түүнийгээ эрүүл мэндэд хоргүй мэт ташаа мэдээллийг хүн амд хүргэсээр байна.

Тамхины хяналттай холбоотой дээрх дутагдлууд улс төрийн чин эрмэлзэл дутмаг байгаатай холбоотой юм. Тамхи үйлдвэрлэгч, импортлогчид улс төрийн хүчнүүдтэй холбоо сүлбээтэй ба хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд эдийн засгийн хүчтэй нөлөө үзүүлж байна. Санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгосон УИХ-ын 12 гишүүнээс нэг нь ч ТХСК-ийн талаар мэдэхгүй байсан нь сэтгэл түгшээсэн асуудал юм. Мөн ярилцлага өгсөн нэгээс бусад бүх гишүүд тамхины

үйлдвэрлэлийг дэмжсэн, түүнд төрийн оролцоог аль болох бага байлгаж, зах зээлийн жамаар нь хөгжүүлэхийг санал болгож байсан нь туйлын харамсалтай. Цаашилбал, тамхины хяналтын талаар төрөөс хийж чадах зүйл хомс, хувь хүн өөрөө л тамхи үйлдвэрлэгч, худалдаачдын арганд орохгүй байх нь чухал гэсэн үзэл санаа цөөнгүй илэрч байв.

6. Зөвлөмжүүд

- Тамхины хяналтын үндэсний салбар хоорондын хороо байгуулж, түүнд Засгийн газар, ТББ, иргэний нийгмийн төлөөллийг тэгш хангаж, тамхины хяналтыг манлайлах хүч болгох;
- Бүх түвшний бодлого ба шийдвэр гаргагч нарт чиглэсэн ухуулга сурталчилгааны кампанит ажлыг тогтмолжуулж, тамхины хяналтын асуудлаар улс төрийн манлайлал бий болгох;
- Орон нутгийн засаг захиргааны оролцоог хөхиүлэн дэмжиж, тамхины хяналтын төвлөрлийг сааруулах;
- Тамхины хяналтын бодлогын бичиг баримтуудыг ТХСК болон өөр хооронд нь уялдуулан нийцүүлэх (ялангуяа эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний талаар мэдээллийг тамхины сав баглаан дээр байрлуулах, олон нийтийн газар тамхи татахыг хориглох, тамхи үйлдвэрлэгчид болон импортлогчдын зүгээс тамхины хорт бодисын агууламж, тэдгээрийн ялгарах хэмжээг үнэн зөвөөр мэдээлэх асуудлуудаар);
- Сургуулийн байгууллагуудад тамхины хяналтын бодлого, хөтөлбөрүүдийг бэхжүүлэх;
- Тамхи үйлдвэрлэгчдийн ташаа, төөрөгдүүлсэн мэдээллийн эсрэг шинжлэх ухааны нотолгоо бүрдүүлэх судалгааны ажлуудыг хийх;
- Тамхины эдийн засгийн үр нөлөөний үнэлгээ хийх;
- Тамхи үйлдвэрлэгчид сурталчилгаанд хэдий хэмжээний хөрөнгийг, мэдээллийн аль хэрэгсэлд өгч байна гэдгийг тогтоох аудит хийх;
- Бүс нутаг дахь тамхины хяналтыг бэхжүүлэх үүднээс хөрш зэргэлдээ орнуудтай хамтын ажиллагаагаа өргжүүлэх.

Судалгаанд хамрагдсан бодлогын баримт бичгийн жагсаалт

1. Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай Монгол улсын хууль (1993 онд батлагдсан; 1995, 1997 онд нэмэлт өөрчлөлт орсон)
2. Онцгой албан татварын тухай Монгол улсын хууль (1993 онд батлагдсан; 1994, 1995, 1998, 1999, 2000, 2004 онуудад нэмэлт өөрчлөлт орсон)
3. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай Монгол улсын хууль (1998)
4. Онцгой албан татварын тэмдгийн тухай Монгол улсын хууль (2000 батлагдсан; 2001, 2002, 2003 онуудад нэмэлт өөрчлөлт орсон)
5. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай Монгол улсын хууль (2001)
6. Зар сурталчилгааны тухай Монгол улсын хууль (2002)
7. Тамхины хяналтын тухай Монгол улсын хууль (2005)
8. Олон нийтийн радио телевизийн тухай Монгол улсын хууль (2005)
9. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого УИХ-ын 81-р тогтоол (2001)
10. Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 224-р тогтоол (2001)
11. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай Засгийн газрын 149-р тогтоол (2002)
12. Улсын мэргэжлийн хяналтын албаны нийтлэг дүрэм, Засгийн газрын 37-р тогтоол (2003)
13. Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 246-р тогтоол (2005)
14. Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Нийслэлийн засаг даргын А/88 тоот захирамж (1994)
15. Монгол улсын хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын эрүүл ахуй, халдвар судлалын ерөнхий байцаагчийн 2 тоот тушаал (1994)
16. Тамхины хор хөнөөлтэй тэмцэх арга хэмжээний тухай Худалдаа, үйлдвэрийн сайдын 48 тоот тушаал (1994)
17. Хууль хэрэгжүүлэх тухай Дэд бүтцийн хөгжлийн сайдын 33 тоот тушаал (1994)

18. Тамхины хор хөнөөлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай Эрүүл мэндийн сайдын А/15 тоот тушаал (1994)
19. Тушаалд өөрчлөлт оруулах тухай ЭМНХ-ын сайдын А/402 тоот тушаал (1997)
20. Журам батлах тухай Санхүү, эдийн засгийн сайдын 41 тоот тушаал (2001)
21. Зүрх судасны өвчнөөс сэргийлэх, тэмцэх хөтөлбөр, ЭМНХ-ын сайдын 194 тоот тушаал (2000)
22. Журам батлах тухай (тамхи импортлоход зөвшөөрөл олгох, түүнд эрүүл ахуйн хяналт хийх тухай) ЭМНХ-ын сайдын 228 тоот тушаал (2000)
23. Янжуур тамхи - техникийн ерөнхий шаардлага, Монгол Улсын стандарт (2001)
24. Онцгой албан татварын тэмэггүй болон хуурамч тэмдэг бүхий архи, тамхийг хураан авч улсын орлого болгох журам батлах тухай Үндэсний татварын ерөнхий газрын даргын 84 тоот тушаал (2001)
25. Импортын архи, дарс, тамхины онцгой албан татвар болон онцгой албан татварын тэмдгийн талаарх мэдээлэл солилцох журам батлах тухай Үндэсний татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын даргын хамтарсан 159/446 тоот тушаал (2002)
26. Журам батлах тухай (зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлс, эмэнд гаалийн бүрдүүлэлт хийх журам) Гаалийн ерөнхий газрын даргын 115 тоот тушаал (2002)
27. Нийгмийн эрүүл мэндийн аймаг, нийслэлийн салбар зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм, НЭМ-ийн Үндэсний зөвлөлийн 2002 оны 09-р сарын 30-ны өдрийн хурлын шийдвэр
28. Хилийн мэргэжлийн хяналтын албаны дүрэм батлах тухай Улсын мэргэжлийн хяналтын газрын даргын 134 тоот тушаал (2003)
29. Тайлангийн маягт, загварыг шинэчлэн батлах тухай Үндэсний татварын ерөнхий газрын даргын 115 тоот тушаал (2005)

Бодлогын баримт бичгийн тойм хийх хяналтын хуудас

Баримт бичгийн нэр

Баталсан шийдвэрийн
нэр, дугаар, огноо

Бодлогын хэрэгжих
хугацаа

Нэг. Ерөнхий зүйл

1. Тамхины хяналтыг хариуцсан үндэсний зохицуулах механизм байгуулах тухай заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

2. Тамхины хяналтыг хариуцсан үндэсний зохицуулах механизм байгуулахыг дэмжсэн заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

3. Тамхины хяналтыг хариуцсан үндэсний зохицуулах механизмыг санхүүжүүлэх тухай заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

4. Тамхины хэрэглээнээс сэргийлэх буюу хэрэглээг бууруулах талаар заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

Хоёр. Тамхины эрэлтийг бууруулах үнэ, татварын арга хэмжээ

5. Тамхины татварын бодлогын талаар заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

6. Тамхины үнийн бодлогын талаар заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

7. Олон улсын зорчигчдод татвараас чөлөөлсөн тамхи зарах буюу импортлохыг хориглосон/хязгаарласан заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

Гурав. Тамхины хорт нөлөөнөөс хамгаалах арга хэмжээ

8. Ажлын байранд, олон нийтийн зорчигч тээвэр, олон нийтийн бусад газарт хүмүүсийг тамхины утаанд өртөхөөс хамгаалах талаар заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

9. Тамхины хорт бодисын агууламж, ялгарах хэмжээг тогтоох, шинжилгээ хийх талаар заалт орсон байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

10. Тамхины хорт бодисын агууламж, ялгарах хэмжээг Засгийн газарт үнэн зөвөөр мэдээлэхийг тамхи үйлдвэрлэгчид болон импортлогчдоос шаардсан заалт орсон байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

11. Тамхины хорт бодисын агууламж болон ялгарах хорт бодисын талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох арга хэмжээ авахыг тамхи үйлдвэрлэгчид болон импортлогчдоос шаардсан заалт орсон байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

Дөрөв. Тамхины сурталчилгааны эсрэг арга хэмжээ

12. Тамхины эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, хорт бодисын агууламж зэргийн талаар буруу, төөрөгдүүлсэн, худлаа мэдээлэл (“зөөлөн”, “бохь багатай” г.м.)-ийг тамхины сав баглаан дээр байрлуулахыг хориглосон заалт орсон байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

13. Тамхины эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, шинж чанар зэргийн талаар үнэн зөв мэдээллийг тамхины сав баглаан дээр байрлуулахыг шаардсан заалт орсон байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

14. Тамхины сав баглаан дээр байрлуулах мэдээллийг эрх мэдэл бүхий этгээдээр батлуулахыг шаардсан заалт орсон байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

15. Тамхины сав баглаан дээр байрлуулах мэдээллийн хэлбэрт тавигдах шаардлага (ж.нь, том, харагдахуйц, нийт харагдах талбайн 30-аас доошгүй хувийг эзэлсэн, тогтмол шинэчлэгдэж байна г.м.)-ыг тусгасан заалт орсон байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

16. Тамхины хорт бодисын агууламж, ялгарах хэмжээний талаар үнэн зөв мэдээллийг тамхины сав баглаан дээр байрлуулахыг шаардсан заалт орсон байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

17. Тамхины сав баглаан дээр байрлуулах мэдээллийг жижиглэнгийн болон бөөний савлагаан дээр заавал байрлуулахыг шаардсан заалт орсон байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

18. Тамхины сав баглаан дээр байрлуулах мэдээллийг албан ёсны хэл дээр байхыг шаардсан заалт орсон байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

19. Тамхины хор хөнөөлийн талаар олон нийтэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах талаар заалт орсон байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

20. Тамхитай тэмцэх үйл ажиллагаанд улсын болон хувийн бусад салбаруудын оролцоог дэмжсэн/шаардсан заалт орсон байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

21. Тамхины сурталчилгааг радио, телевиз, хэвлэл, Интернет зэрэг мэдээллийн бүхий л сувгаар явуулахыг хориглосон заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

22. Тамхины сурталчилгааг хориглосон заалт байхгүй бол сурталчилгаанд зарцуулж буй нийт хөрөнгийн хэмжээг засгийн газарт үнэн зөв мэдүүлж байхыг тамхи үйлдвэрлэгчид болон импортлогчдоос шаардсан заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

23. Тамхины үйлдвэрлэгчид болон импортлогчдыг олон улсын арга хэмжээ, үйл ажиллагаа болон оролцогчдыг ивээн тэтгэхийг хориглосон заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

24. Тамхины хэрэглээг дэмжсэн шууд буюу шууд бус урамшуулал (хонжвор, сугалаа г.м.)-ыг хориглосон заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

Тав. Тамхинаас гаргах арга хэмжээ

25. Боловсрол, эрүүл мэндийн байгууллага, ажлын байр болон спортын арга хэмжээний үеэр тамхинаас гаргахад чиглэсэн үр дүнтэй хөтөлбөр хэрэгжүүлэх талаар заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

26. Тамхинд донтох өвчнийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх, зөвлөгөө өгөх хөтөлбөрүүдийг эрүүл мэндийн байгууллага, нөхөн сэргээх төвүүдэд хэрэгжүүлэх талаар заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

Зургаа. Тамхины хууль бус худалдаа

27. Тамхины үйлдвэрлэгчийг тодорхойлсон (тамхи хаана үйлдвэрлэгдсэнийг тодорхойлох боломж олгохуйц) мэдээлэл тамхины бүх сав баглаан дээр байхыг шаардсан заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

28. Тамхийг хаана (аль бүс, улс орон г.м.) худалдаалахыг зөвшөөрсөн талаар мэдээлэл тамхины бүх сав баглаан дээр байхыг шаардсан заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

29. Тамхины хил дамнанс худалдаа, хууль бус худалдааны талаар мэдээ цуглуулахыг шаардсан заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

30. Тамхины хууль бус худалдааг хорих, шийтгэл ногдуулах талаар заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

31. Тамхины хууль бус үйлдвэрлэл, худалдаанаас олсон ашгийг хураах талаар заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

32. Тамхины хууль бус үйлдвэрлэл, худалдаа эрхлэхэд ашиглаж байсан тоног төхөөрөмж, тамхи, тамхин бүтээгдэхүүнийг устгах талаар заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

33. Тухайн нутаг дэвсгэр дээр үйлдвэрлэгдэж, хадгалагдаж, худалдаалагдаж буй тамхины хөдөлгөөнийг хянах, баримтжуулах, хянах арга хэмжээ авах талаар заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

34. Тамхины хууль бус үйлдвэрлэл, худалдааг устгахын тулд тамхины үйлдвэрлэл, худалдаа эрхлэх үйл ажиллагааг лицензжүүлэх талаар заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

Долоо. Тамхийг хүүхдүүдэд худалдах, тэдгээрээр худалдуулахыг хорих тухай

35. Тамхийг хүүхдүүдэд худалдахыг хориглосон заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

36. Тамхийг хүүхдүүдэд худалдахгүй талаар тодорхой, харагдахуйц самбарыг тамхи худалдаалж буй цэг бүрт байрлуулахыг шаардсан заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

37. Тамхийг шууд хүртээмжтэй хэлбэрээр (ж.нь, өөртөө үйлчлэх тасгийнлангуугаар) худалдахыг хориглосон заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

38. Чихэр, амттан, тоглоом зэрэг хүүхдүүдийн сонирхлыг татахуйц зүйлсийг тамхины хэлбэртэй үйлдвэрлэх, ийм зүйлсийг худалдахыг хориглосон заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

39. Тамхийг үнэгүй тараахыг хориглосон заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

40. Тамхийг ширхэглэн буюу жижиг савлагаатайгаар худалдахыг хориглосон заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

41. Тамхийг хүүхдээр худалдуулахыг хориглосон заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

42. Тамхийг хүүхдэд худалдах, тэдгээрээр худалдуулахыг хориглосон заалтуудыг зөрчсөн хүнд авах арга хэмжээний талаар заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

Найм. Тамхины судалгаа, мэдээлэл солилцох үйл ажиллагаа

43. Тамхины хэрэглээний шалтгаан, үр дагаврын талаарх судалгаа, шинжилгээний ажлыг дэмжсэн заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

44. Тамхины судалгаа, тамхитай тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үнэлэхэд оролцож буй мэргэжилтнүүдийг сургалтад хамруулах, бусад дэмжлэг үзүүлэх талаар заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

45. Тамхины тандалтын мэдээ цуглуулах, дүн шинжилгээ хийх, тараах удирдамж боловсруулах талаар заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

46. Тамхины хяналтын талаарх хууль, журмуудын мэдээний сан байгуулж, байнга шинэчлэх талаар заалт байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

Ес. Бусад

Хэвлэл мэдээллийн тойм хийх хяналтын хуудас

Хэвлэл мэдээллийн
хэрэгслийн нэр

Дугаар, огноо

1. Тамхины эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, хорт бодисын агууламж зэргийн талаар буруу, төөрөгдүүлсэн, худлаа мэдээлэл (“зөөлөн”, “бохь багатай” г.м.)-ийг өгсөн байна уу?

Тийм (тодруулна уу) _____

Үгүй

2. Тамхины эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, шинж чанар зэргийн талаар үнэн зөв мэдээллийг өгсөн байна уу?

Тийм (тодруулна уу) _____

Үгүй

3. Тамхины эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, шинж чанар зэргийн талаарх мэдээлэл нь том, харагдахуйц (нийт харагдах талбайн 30-с доошгүй хувийг эзэлсэн) байна уу?

Тийм (тодруулна уу) _____

Үгүй

4. Тамхины хорт бодисын агууламж, ялгарах хэмжээний талаар үнэн зөв мэдээллийг өгсөн байна уу?

Тийм (тодруулна уу) _____

Үгүй

5. Тамхины эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, шинж чанар зэргийн талаарх мэдээлэл нь албан ёсны хэл дээр байна уу?

Тийм (тодруулна уу) _____

Үгүй

6. Тамхины хор хөнөөлийн талаар олон нийтэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулж байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

7. Тамхины үйлдвэрлэгчид болон импортлогчид олон нийтийн арга хэмжээ, үйл ажиллагааг ивээн тэтгэсэн талаар мэдээ байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

8. Тамхины хэрэглээг дэмжсэн шууд ба шууд бус урамшуулал (хонжвор, сугалаа г.м.)-ын талаар мэдээ байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

9. Тамхийг хүүхдэд худалдаалахгүй талаар тодорхой, харагдахуйц мэдээлэл байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

10. Чихэр, амттан, тоглоом зэрэг хүүхдийн сонирхлыг татахуйц зүйлсийг тамхины хэлбэртэй үйлдвэрлэж, худалдаалж байгаа талаар мэдээ байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

11. Тамхийг үнэгүй тараах талаар мэдээ байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

12. Тамхийг ширхэгчлэн буюу жижиг савлагаатайгаар худалдаалж байгаа талаар мэдээ байна уу?

Тийм (заалтыг бичнэ үү) _____

Үгүй

Бусад

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН СУУРЬ КОНВЕНЦИ (ТХСК)-ИЙН
ТАЛААР ХУУЛЬ ТОГТООГЧИДТОЙ ХИЙХ ЯРИЛЦЛАГЫН АСУУЛТ**

Ярилцлагад оролцсон
хүний овог нэр

Байгууллагын нэр,
албан тушаал

Ярилцлага хийсэн
огноо

1. Монгол улсад тамхины хяналтын талаар ямар хууль, журам үйлчилдэг вэ?

2. Тамхины хяналтын тухай Монгол улсын хууль журмын хэрэгжилтийг Та хэрхэн үнэлэх вэ?

сайн дунд муу

3. Тэдгээрээс ямар заалтууд хамгийн их зөрчигдөж байна вэ?

4. Эдгээр заалтууд зөрчигдөж байгаагийн шалтгаан юу вэ?

5. Манай улсад тамхины сурталчилгаа болон ивээн тэтгэх явдлын талаар Та ямар бодолтой байдаг вэ?

6. Тамхины сурталчилгааг бүрэн зогсоохын тулд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж Та үзэж байна вэ?

7. Тамхийг ширхэглэн худалдаалахыг Та юу гэж боддог вэ?

8. Тамхийг ширхэглэн худалддагийг болиулах талаар Таны бодол?

9. Монголд тамхины үйлдвэр бий юу? Тамхины үйлдвэрлэлийн талаар Таны бодол?

10. Тамхины хэрэглээг бууруулахын тулд ямар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж Та үздэг вэ?

11. Тамхины хяналтын хууль журмын хэрэгжилтийг сайжруулах ямар арга замууд байж болох вэ?

12. Та тамхи татдаг уу?

Ярилцлага өгсөн УИХ-ын гишүүдийн нэрс, огноо

1.	Р. Эрдэнэбүрэн	2006. 07. 06
2.	Н. Батбаяр	2006. 07. 06
3.	Б. Батбаатар	2006. 04. 03
4.	Т. Бадамжунай	2006. 07. 06
5.	Б. Батбаяр	2006. 07. 06
6.	Д. Дондог	2006. 06. 29
7.	Д. Арвин	2006. 04. 12
8.	Р. Буд	2006. 07. 06
9.	Ц. Шаравдорж	2006. 04. 02
10.	Г. Адьяа	2006. 06. 29
11.	С. Ламбаа	2006. 07. 06
12.	Р. Бадамдамдин	2006. 07. 06